

БАТЛАВ.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГА Ж.ДАШ-ЯЙЧИЛ



**ГЭР ХОРООЛЛЫН ӨРХИЙН ХАШААНД АНГИЛАН ЯЛГАХ
ХОГИЙН САВЫГ ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР**

2024.03.01

Зуунмод

1. Зорилго: Хог хаягдлын тухай хууль /9 дүгээр зүйлийн 9.3.9 дах заалт: хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэнд оруулах зорилгоор ангилан ялгах, дахивар нөөц цуглуулах, дахин боловсруулах, сэргээн ашиглах үйл ажиллагааг зохион байгуулж, санхүүгийн дэмжлэг үзүүлэх/ -ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гэр хорооллын өрхийн хашаанд ангилан ялгах хогийн савыг нэмэгдүүлэх, иргэдийн эрүүл аюулгүй орчинд ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Алтанбулаг, Зуунмод сумдын гэр хорооллын айл өрхийн хашаанд ангилан ялгах хогийн савыг нэмэгдүүлж, шинээр хийх зорилготой болно.
2. Үндэслэл: Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 17-р хуралдааны 3-р тогтоолын 6 дугаар хавсралтын 3 дах заалт.
3. Хугацаа: Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, нийтийн эзэмшлийн орон сууцны хогийн савыг хийж, тогтоосон газруудад байрлуулах ажлыг 2024 оны 03 сарын 01-ны өдрөөс эхлэн 2024 оны 05 сарын 20-ны өдрийн хооронд зохион байгуулна.
4. Санхүүжилт: Ажлын нийт төсөв 60.000.000 /жаран сая /

№	Хамтрах хүрээ	Нэгж өртөг	Хогийн савны тоо	Нийт өртөг
1	Алтанбулаг сум	500.000	60	30.000.000
2	Зуунмод сум	500.000	60	30.000.000
	Нийт		120	60.000.000

5. Ажлын хамрах хүрээ: Алтанбулаг, Зуунмод сумын нийт 120 өрх /хавсралт-1/
6. Тавигдах шаардлага: Гэр хорооллын өрхийн хашаанд байрлах ангилан ялгах хогийн сав нь хог хаягдлыг 3 ангилан хаях зориулалт бүхий таславчтай, сайн чанарын төмөр рамтай, эх бие нь жижиг нүхтэй торон, үнс хийх хэсэгт бариултай битүү сав байрлуулсан байна.

6.1 Хэмжээ:

- Нүүрэн тал буюу хашааны гадна хэсгийн өндөр 1-1,2 метр



- Таславч хоорондын зай 0,6-0,8 метр
- Үнсний сав байрлуулах багтаамж 0,08-0,12 метр куб

6.2 Ангилал ялгах дараах 3 хэсгийн тус бүр өнгөөр ялган будна:

- Дахивар хаягдал
- Үнс
- Бусад хаягдал

6.3 Ангилан ялгах хогийн саванд тавигдах ерөнхий шаардлага:

- Нүүрэн талын хаалганууд хажуу тийш онгойх зориулалттай, нугас, түгжээтэй байна.
- Хашааны дотор талаас онгойлгож хогоо хийх зориулалттай нугас, бариултай, торон байх
- Хогийн савны нүүр болон суурь хэсгийг сайн чанарын төмөр листээр хийх,
- Үнс ангилан ялгах хэсгийг давхар савтай хийх
- Ангилал бүрт таславчтай, хог хийх хэсэг болон тээвэрлэх ачих нөхцөлийг бүрдүүлсэн байх
- Өрхийн хашаанд суурьлуулахдаа хөлтэй савыг, тэгш газарт байрлуулна.
- Гэр хорооллын өрхийн хашаанд байрлах хогийн савны ерөнхий загвар зураг



/Загвар зураг/



/Бодит зураг/

Нэг хогийн савны төсөвт өртгийн тооцоо

№	Бараа материалын нэр төрөл	Хэмжих нэгж	шаардлагатай тоо, хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Лист төмөр /зузаан 1.5 мм-ээс доошгүй, Нүүр, доод хэсэг, үсний хайрцаг/	М2	3.2	48500	155,200
2	Уголник төмөр	М	26		55,000
3	профиль төмөр 30*30 / метр / /зузаан 2мм-ээс доошгүй/	м	3	5000	15,000
4	Төмөр тор	м2	1.2*2.4		55,000
5	Төмрийн будаг	л	1	30000	30,000
7	Түгжээ	ш	2	5500	11,000
8	Нугас	ш	10	2000	20,000
9	Бариул	ш	2	3000	6,000
10	Электрод	ш	10	3000	30,000
11	Таслагч ир	ш	1	6000	6,000
12	Зүлгүүр	ш	1	6000	6,000
14	Тээвэр				29,600
15	Цалин хөлс	хүн/өдөр	1	30000	30,000

16	Хөдөлмөр хамгааллын бээлий	ш	1	1200	1,200
18	Нийт үнэ				450,000
19	НАӨТ				50,000
20	НӨАТ.тай үнэ				500,000

7. Хяналт: Захиалагч талаас гүйцэтгэгчийн явцын үйл ажиллагаанд 2-оос багагүй удаа, материалын чанар, загвар, хийц, төлөвлөгөөт ажлын явцад хөндлөнгийн хяналтыг хийнэ.

8. Үр дүнг тайлагнах

Гэр хорооллын өрхийн хашаанд байрлуулах хогийн савыг гэрээнд заасан хугацаанд хийж, гүйцэтгэсэн ажил дууссан өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Алтанбулаг, Зуунмод сумдын Засаг даргын тамгын газарт ажил хүлээлцэх акт үйлдэн хүлээлгэн өгнө.

Ажлын даалгавар боловсруулсан:

Байгаль орчин аялал жуулчлалын газрын мэргэжилтэн

М.Цээпил

ГЭР ХОРООЛЛЫН АЙЛ ӨРХИЙН ХАШААНД БАЙРЛУУЛАХ
АНГИЛАН ЯЛГАХ ХОГИЙН САВ

№	Сумын нэр	Багийн нэр	Тоо ширхэг
1	Алтанбулаг	Сумын саналаар	60
2	Зуунмод	2,3,5	60

---oOo---